

Жилийн тайлан 2023.

Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК



Эрхэм зорилго:

Дижитал банкийг таны гарг

Алсын хараа:

Дижитал эринд финтек хувьслаар манлайлна

АГУУЛГА.

Netcapital Annual Report 2023

○ 2023 оны онцлох	3
○ Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	4
○ ТУЗ-ийн даргын мэндчилгээ	5
○ Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	6
○ Нийгмийн хариуцлага	7
○ Компанийн засаглал	9
○ ТУЗ-ийн мэдээлэл, үйл ажиллагааны тойм	11
○ Санхүүгийн гүйцэтгэл	15
○ Макро эдийн засаг 2023	16
○ Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл	19
○ Хүний нөөцийн бодлого, сургалт хөгжил, соёлын арга хэмжээ	20
○ Компанийн онцлох үйл явдлууд	25
○ Дижитал шилжилт болон онцлох үйл явдлууд	32
○ Эрсдэлийн удирдлага	36
○ Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг	41



NET CAPITAL
financial corporation

2023 оны онцлох.

Нийт хөрөнгө
131.6 тэр.₮





Зээлийн багц
112.8 тэр.₮

Эх үүсвэр
91.7 тэр.₮


Салбар, нэгж
36

Ажилтан
471+


Харилцаагч
100,000+




Цэвэр ашиг +62%



Өөрийн хөрөнгийн өгөөж (%)



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)



ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

	Шалгуур	Биелэлт/2022/	Биелэлт/2023/	
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	>10%	37.2%	31.6%	
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	>20%	37.2%	31.6%	
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	>8%	8.8%	17.5%	
Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	<30%	0.9%	0.7%	
ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал, ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	<25%	6.0%	0.3%	
ББСБ-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	<10%	4.7%	0%	



ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ.

2023.12.31

Д.Алтангэрэл

ТУЗ-ИЙН ДАРГА

Сайн байцгаана уу,

Эрхэм харилцагч, хамтран ажиллагч түншүүд, хувьцаа эзэмшигч та бүхэндээ компанийхаа 2023 оны жилийн тайлангаар мэндчилж буйдаа баяртай байна.

2023 онд бид “Бүтээмж-Борлуулалтын жил” уриатайгаар стратегийн хүрээнд Орон нутагт дахин 7 салбарыг шинээр нээж, 40 гаруй ажлын байрыг бий болголоо. Ингэснээр бид Монгол улсынхаа 21 аймгийн харилцагч наарт илүү ойртоож, санхүүгийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх боломжтой болов.

Мөн бид 2024 оныг “Дэвшилтэт технологийн жил” болгох стратегийн зорилгын хүрээнд дижитал шилжилтийн суурийг бэлдэж, сүүлийн 2 жил орчмын хугацаанд дотооддоо хөгжүүлсэн томоохон технологийн төсөл болох “НэтКор” үндсэн системийн хөгжүүлэлтийг бүрэн дуусч, үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна. Үндсэн системээ дотооддоо хөгжүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн анхны ББСБ болж, дижитал шилжилтэд түүчээллээ.

Компанийн сайн засаглал, үйл ажиллагааны тогтвортой өсөлттэй байдал, эрсдэлийн удирдлагын хүчирхэг соёлд тулгуурлан үйл ажиллагаа явуулж байгаа нь гадны компанийн итгэлийг хүлээж Сингапур улсын хөрөнгө оруулалтын сантай 9сая ам.долларын гэрээг амжилттай үзэглэв.

Ирэх жилүүдэд бидэнтэй хамт байж технологид суурилсан санхүүгийн бүхий л төрлийн үйлчилгээг хариуцлагатай иргэн бүрд хүргэж, нийгмийн хүчирхэг дундаж давхаргыг бий болгох урт аялалд минь хамтдаа байж, амжилт өөд тэмүүлэх хүндэт харилцагч, түншүүд, ТУЗ-ийн гишүүд та бүхэндээ амжилт хүсэж, талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

“Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Алтангэрэл



Гүйцэтгэх захирлын мэндчилгээ.

Б.Хуншагай

Гүйцэтгэх захирал

Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК-ийн нийт харилцагчид, түншүүд та бүхэндээ 2023 оны жилийн тайлангаа танилцуулж буйдаа туйлын таатай байна.

2023 онд компанийн нийт актив хөрөнгө 20 хувиар өсөж 131 тэрбум төгрөгт, харилцагчид олгосон зээлийн хэмжээ 44 хувиар өсөж 112.8 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Бидэнд итгэл хүлээлгэн үйлчилгээ авдаг 100,000 гаруй үнэнч харилцагч, түншүүддээ болон компанийнхаа төлөө, харилцагч нарынхаа төлөө гэсэн сэтгэл, зүтгэлтэй 471 ажилтнууддаа талархал илэрхийлье.

Дижитал эринд финтек хувьслаар манлайлах эрхэм зорилгын хүрээнд 2023 онд дижитал шилжилтийн суурийг бэлдэж, дэд бүтэц, хүний нөөц талдаа бидний зүгээс тасралтгүй хөрөнгө оруулалтыг хийллээ.

2024 онд бид одоогийнхоос илүү “Харилцагч төвтэй байгууллага” болохыг зорьж, Хиймэл оюунд сууриссан технологийн шийдлүүдийг үйл ажиллагаандaa эрчимтэй нэвтрүүлэх, харилцагч бүрийнхээ хэрэгцээ шаардлагад илүү нийцэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгохоор зорин ажиллаж байна.

Ирэх жилүүдийн хамтын өсөлт хөгжил, хиймэл оюунд сууриссан бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагч таны гарт хүргэх зорилгын хүрээнд хамтран ажиллах нийт түншүүд, харилцагчид, удирдлагын баг, ажилтнууд та бүхэндээ амжилт хүсэж, талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

“Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Хуншагай

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА.

1

Булган аймаг

Булган аймгийн төвд 7 цэцэрлэгт ариутгагч кварц гэрэл, агаар чийгшүүлэгчийн хамт хандивлав.



2



Төв аймаг

Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн хашаанд амарч суух, агаарлах зориулалттай 2ш сүүдрэвчийг тохижуулав.

3



Налайх дүүрэг

Налайх дүүргийн ТҮК-д багаж хэрэгсэл хандивлав.

4



Багануур дүүрэг

Багануур дүүргийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт нярайн шарлагын 3ш аппарат, утлагын 3ш аппарат хандивлав.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА.

5



Хэнтий аймаг

Хэнтий аймагт төв зам дагуу 100м талбайд 30ш нарс мод тарьж, тус талбайг гэрлээр тойруулан тохижуулав.

6



Сүхбаатар аймаг

Сүхбаатар аймагт 2023 оныг хүүхэд хөгжлийн жил болгон зарласантай холбоотой аймгийн биеийн тамир спортын газарт сагс, волейболын бөмбөг болон бусад хэрэгслийг хандивлав.

7



Дундговь аймаг

Дундговь аймгийн ид шидийн оронд хүүхдүүдэд зориулан шатар, шатрын цаг, нүүдэл заах хөөсөнцөр самбар, ханын шатар зэрэг зүйлсийг хандивлав.

8



Ид шидийн орон

06-н сарын 01-ыг тохиолдуулан Ид шидийн ороны хүүхдүүдийн дунд “Дижитал эриний хүүхдүүд” гар зургийн уралдааныг зарлан, насны ангилалаар шалгаруулж унадаг дугуй, номын эрхийн бичиг, бэлгийн багц өгсөн.

Компанийн засаглал.

Netcapital Annual Report 2023

Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК нь Монгол Улсад бүртгэлтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдсан ББСБ бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоос гадна банкнаас бусад зохицуулалттай салбарын зохицуулагч Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)- оос баталсан Компанийн засаглалын кодексийг дагаж мөрдөх үүрэгтэй.

СЗХ-ны 2023 оны “Компанийн засаглалын кодексийн зайн үнэлгээ”-гээр Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК нь **2 дах жилдээ** засаглалаараа тэргүүлэгч **ТОП-5 ББСБ-н нэг** боллоо.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС ҮНЭЛГЭЭ ТОП-5 ББСБ - 2023

Санхүүгийн зохицуулах хороо 2023 онд ББСБ, Даатгал, ХОМК-иудад дахин компанийн засаглалын зайн үнэлгээг хийж, хэрэгжилтийн үнэлгээний тайланг гаргав.

“Нэткапитал Финанс Корпораци ББСБ” ХХК нь 2 ДАХ ЖИЛДЭЭ салбартаа үнэлгээгээр тэргүүлэгч ТОП-5 ББСБ-н 1 боллоо.

Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч байгууллагууд

ТОП 5
ББСБ



НЬЮФОНД ХХК

ҮЙЗЭН-ИВЭЭЛ
ББСБ ХХК



ТОП 5
ДААТГАЛ



КОДЕКС үнэлгээ 2023 – 94.4%

КОДЕКС үнэлгээ 2022 - 84.7%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ.

2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарахаар заасан асуудлуудаас бусад бүх асуудлаар шийдвэр гаргадаг.

2023 оны 12 дугаар сарын байдлаар ТУЗ нь Хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлсэн 2 гишүүн, 5 хараат бус гишүүнээс бүрдсэн бүрэлдэхүүнтэй байна.

ТУЗ-ийн даргын үүргийг хувьцаа эзэмшигч бус, хараат бус байр суурьтай гишүүн гүйцэтгэдэг ба ТУЗ-ийн бүрэлдэхүүнд банк, даатгал, технологи, үл хөдлөхийн салбарын олон талын туршлагатай, ур чадвартай гишүүд ажилладаг.

Нийт гишүүдийн 70-с дээш хувь нь хараат бус гишүүн байдаг тул шийдвэр гаргалт хараат бус гардаг.

Д/д	Нэр	Албан тушаал
1	Доржрэнцэн АЛТАНГЭРЭЛ	ТУЗ-ийн дарга
2	Нэргүй ҮНДРАХ	ТУЗ-ийн гишүүн
3	Лхагватөмөр ОРГИЛ	ТУЗ-ийн хараат бус гишүүн
4	Баатарзоригт БОЛОРЧИМЭГ	ТУЗ-ийн хараат бус гишүүн
5	Алтангэрэл УРАНГОО	ТУЗ-ийн хараат бус гишүүн
6	Батчулуун МӨНХЖАВХАА	ТУЗ-ийн хараат бус гишүүн
7	Шарав ЧУДАНЖИЙ	ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД.

Netcapital Annual Report 2023



Д.АЛТАНГЭРЭЛ

ТУЗ-ИЙН ДАРГА

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оноос компанийн ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна.

Мэдээллийн технологи, эрх зүйн чиглэлээр мэргэжилтэй ба 2008 оноос Монголын томоохон байгууллагуудад удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай.

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ БАЙДЛААР



Н.УНДРАХ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2020 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Банк, санхүүгийн мэргэжилтэй ба 1998 оноос хойш санхүүгийн салбарт ажиллаж байна. Монголын томоохон хувийн хэвшлийн байгууллагуудад удирдах албан тушаалыг хашиж байсан туршлагатай

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ БАЙДЛААР



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД.

Netcapital Annual Report 2023



Л.ОРГИЛ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Компанийн ТУЗ-д:

2022 оноос

Ажлын туршлага:

15 жил, Банк, санхүү, даатгалын салбар



Б.БОЛОРЧИМЭГ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС
ГИШҮҮН

Компанийн ТУЗ-д:

2021 оноос

Ажлын туршлага:

12 жил, Сэтгүүл зүйн салбар



А.УРАНГОО

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС
ГИШҮҮН

Компанийн ТУЗ-д:

2020 оноос

Ажлын туршлага:

11 жил, Ул хөдлөх хөрөнгийн салбар



Б.МӨНХЖАВХАА

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Компанийн ТУЗ-д:

2022 оноос

Ажлын туршлага:

14 жил, Банк, санхүүгийн салбар



Ш.ЧУДАНЖАЙ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Компанийн ТУЗ-д:

2020 оноос

Ажлын туршлага:

31 жил, Банк, санхүүгийн салбар

ТУЗ-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Төрөл | **ТУЗ-ийн хурал**

 ХУРЛЫН ТОО
18

 ШИЙДВЭРИЙН ТОО
25



Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны Засаглалын кодекст нийцүүлж, дараах шийдвэрүүдийг гарган ажиллалаа.

1. Компанийн Стратеги төлөвлөгөө болон Бизнес төлөвлөгөөг батлах
2. Шинээр тусгай зөвшөөрөл авахтай холбоотой
3. Итгэлцлийн үйлчилгээний журам батлах тухай
4. Дотоод Аудитын төлөвлөгөөг батлах
5. ХЭ-н ээлжит болон ээлжит бус хурлуудыг зарлан хуралдуулах
6. Салбарын захирлуудын өөрчлөлт
7. ТУЗ-ийн хороодод гишүүн томилох тухай





Төрөл | **ТУЗ-ийн дэргэдэх Хороод**

 ХУРЛЫН ТОО
4

 ДҮГНЭЛТИЙН ТОО
4



Санхүүгийн гүйцэтгэл.

Netcapital Annual Report 2023



МАКРО ЭДИЙН ЗАСАГ - 2023


БАНКНЫ ЗАХ ЗЭЭЛ



- Банкны актив **57.0 и.н хүрч** 11.1 и.н буюу **24% өссөн**
- Өсөлтөнд нийт зээлээс гадна **төв банкны үнэт цаас өссөн**
- Пассив талдаа харилцах, хугацаатай хадгаламж **7.2 и.н өссөн**
- Банкууд 2023 онд **1,3 и.н ашигтай** ажиллаж өмнөх жилээс **23% өссөн**

МАКРО ЭДИЙН ЗАСАГ - 2023

ББСБ - Н ЗАХ ЗЭЭЛ





- Салбарын нийт зээлийн багцын 7.4% буюу 194.8 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд байна.


- Салбарын байгуулсан нийт эрсдэлийн сангийн зардал нь салбарын чанаргүй зээлийн 73%-тай тэнцэж байна.

МАКРО ЭДИЙН ЗАСАГ - 2023

ББСБ - Н ЗАХ ЗЭЭЛ



ББСБ-ЫН ТОО



ӨСӨЛТИЙН ХУВЬ

Нийт эх үүсвэрийн багц оны эхэнд **1,006 тб ₮** байсан бол жилийн төгсгөлд **1,555 тб ₮** болж, нийт эх үүсвэрийн багц **54.5%-р** цэвэр өссөн
Итгэлцлийн үйлчилгээ эзлэж байгаа бөгөөд **71%-р**, банкны зээл **47.8%-р**, бондын төлбөр **38.5%-р** тус тус өссөн байна

Мөн улирал бүрээр өсөлтийн хувь нь тогтмол өсөлттэй байгаа нь банк, ААНБ болон иргэд нь ББСБ-д итгэн, хөрөнгө итгэмжлэн удирдуулах болон ББСБ-дын өрийн хэрэгслийн Биржийн болон биржийн бус зах зээлээс худалдан авах хандлагатай болсон байна.

Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйл.

Эрхэм зорилго | Mission

- ✓ Дижитал банкийг таны гарт

Үнэт зүйл | Value

- ✓ Харилцагч төвтэй
- ✓ Хиймэл оюунд суурилсан байгууллага**
- ✓ Платформ бизнес модель
- ✓ Ажайл байгууллага
- ✓ Инноваци ба Бүтээлч байдал (Дизайн тинкинг ба Дизайн спринт)**

Алсын хараа | Vission

- ✓ Дижитал эринд финтек хувьслаар манлайлна

Бидний соёл | Culture

- ✓ Эерэг хандлага /Optimistic/
- ✓ Бүтээлч байдал /Creative/
- ✓ Мэргэжлийн баг/Professional team/**
- ✓ Залуу манлайлал /Young leadership/
- ✓ Тасралтгүй суралцах /Lifelong learning/
- ✓ Амжилтад тэмүүлэгч /Desire for success/

**Компанийн ТУЗ-ийн 2024 оны 03 сарын ээлжит хурлаар шинэчлэв.



Хүний нөөц.

Netcapital Annual Report 2023

Бодлого.

Бид алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, ёс зүйн дүрмийн хүрээнд хүний нөөцийн бодлого тодорхойлж компанийн хүн хүчний төлөвлөлт, хүний нөөц бүрдүүлэх, сонгон шалгаруулах, тогтоон барих, дасан зохицуулах, сургаж хөгжүүлэх, залгамж болон тулхүүр ажилтан бэлтгэх, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг тодорхойлон ажилладаг.

Бид ажилтныг бүрдүүлэх, сонгон шалгаруулах функц дээрээ хүний нөөцийн нээлттэй бодлого баримтлан ажиллаж байна.

Компанийн зорилго ажилтан таны зорилготой нийцэж байхаар мэдлэг, ур чадвартай ажил горилогчийг **"Зөв хүнийг, зөв албан тушаалд, зөв цагт"** нь сонгон шалгаруулж авахыг зорин ажиллаж байна.

2021 оны эцсийн байдлаар Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК нь 155 идэвхтэй ажилтантай байсан бол 2023 оны 12 сарын байдлаар 471 идэвхтэй ажилтантай болж, 316 ажлын байрыг шинээр бий болголоо.

471

Нийт идэвхтэй
ажилтны тоо

128

Төв оффисын
ажилтны тоо

151

УБ хотын салбарын
ажилтны тоо

192

ОН салбарын
ажилтны тоо

5

Дээд шатны
удирдлага

36

Нийт салбар



*Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу ажилтны хүүхэд асрах чөлөөний хугацаанд тухайн ажлын байрыг хадгалж, хүсэлтээ өгснөөс 1 сарын дотор эргэн ороход шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж өгдөг.

КОМПАНИЙН СОЁЛЫН АРГА ХЭМЖЭЭ БА СУРГАЛТ ХӨГЖИЛ.

Quarter 1

1. Орон нутгийн шинэ 7 салбарын нийт 52 ажилтанд 2 өдрийн чиглүүлэх NETVIBE танхимын сургалт зохион байгуулав.
2. УБ салбарын шинэ зээлийн ажилтны чиглүүлэх 2 өдрийн танхимын сургалтыг зохион байгуулав.
3. ТоC ногоон санхүүжилтийн талаарх мэдлэг, мэдээллийг үе шаттайгаар онлайн сургалтанд ажилтнуудаа хамруулав.



Quarter 2

1. Нэг гэр бүл /One big family/ соёлын хүрээнд NC Family-Хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулав.



Quarter 3

1. NET-Picnic-Зуны зугаалга Эерэг хандлага /Optimistic/
2. NetCore иж бүрэн сургалт орсон /Салбар, HQ/.
3. Орон нутгийн салбаруудаар ажлын хэсэг байгуулж аймаг бүрт Харилцагчдад таниулах уулзалт зөвлөгөөн хийсэн.
4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас “Нийт ажилтнуудад мэдлэг олгох сургалт хийгдсэн.



Quarter 4

1. Харилцагчийн үйлчилгээний Талархлын аян зарлаж, аянд шалгарсан салбар болон ажилтнуудаа шагнав.
2. Харилцагчийн үйлчилгээг таниулах аяны хүрээнд нийт ажилтнуудад сургалт хийсэн.



АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ИДЭВХЖҮҮЛЭЛТ.



ШИЛДЭГ 10 АЖИЛТАН – ГАДААД АЯЛАЛ

- “NetCore” үндсэн системийг амжилттай нэвтрүүлсэнтэй холбоотой 10 шилдэг ажилтнаа Турк улсад 8 өдрийн аялалд хамруулав.

KNOWLEDGE SHARING – АРГА ХЭМЖЭЭ

Сэтгэл судлаач-Г.Наранбаатарын лекц

- Ур чадварын тухай лекц - /Харилцаа хандлага, ур чадвар, ёсзүйн тухай/
- Сэтгэлзүйн эрүүл мэнд - /Стресс менежмент/ сургалтанд УБ хотын салбарууд болон Төвийн нийт ажилтнуудаа хамруулав.

ЗАНГИАГҮЙ УУЛЗАЛТ

- Салбарын захирлуудын Зангигагүй уулзалтыг хийж, ажлын уялдаатай хамтран ажиллах нөхцлийг илүү сайжрууллаа.

УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН

- “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 70 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай зохион байгууллаа.

15 ЖИЛИЙН ОЙ

- 15 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан нийт ажилтнууд болон харилцагч нартаа компанийн лого бүхий бэлэг дурсгав.



Бидний нэг болсноор.


Netcapital Annual Report 2023

- Эрэг дулаан уур амьсгалтай, тохилог таатай орчинд ажиллах
- Удирдлага-ажилтнуудын найрсаг жигд харилцаатай соёлд нэгдэх
- Залуу эрч хүчтэй, найрсаг хамт олны нэг болж тасралтгүй суралцах
- Олон улсад нэвтэрсэн сайн ажлын арга барилаас эзэмших
- Өсөн дэвших нээлттэй бодлого, тэгш боломжоор хангагдах
- Чөлөөт цагийг зөв зохицой өнгөрүүлэх сонирхолын клубуудад хамрагдах

Ажилд сонгон шалгаруулах зарчим.

- Бид ажилтныг бүрдүүлэх, сонгон шалгаруулах функц дээрээ хүний нөөцийн нээлттэй бодлого баримтлан ажилладаг.
- Байгууллагын зорилго ажилтан таны зорилготой нийцэж байхаар мэдлэг, ур чадвартай ажил горилогчийг "**Зөв хүнийг, зөв албан тушаалд, зөв цагт**" сонгон шалгаруулж авахыг зорин ажиллаж байна.
- **Сонгон шалгаруулалт хийгдэх үе шат:** Анкет хүлээн авах -> Анкетын сонгон шалгаруулалт -> Шалгалт, тест -> Ярилцлага уулзалт -> Ажилд авах санал -> Нэткапиталжуулах сургалт

Хүний нөөцийн сонгон шалгаруулалт



Тогтмол зохион байгуулагддаг идэвхжүүлэлтийн ажлууд.



NET Academy

- Шинэ ажилтны сургалт
- Улирал бүр



Net-Cup

- Спортын арга хэмжээ
- I-p улирал



NET-Family

- Хүүхдийн баярын арга хэмжээ
- 05/31



NET Naadam

- Баяр наадмын арга хэмжээ
- Үндэсний хувцсаараа гоёх

NC-Summer Trip

- Зуны зугаалга, хөгжөөнт арга хэмжээ
- III-p улирал

NetVibe

- Идэвхжүүлэлтийн арга хэмжээ
- Улирал бүр

NC- New Year

- Шинэ жилийн арга хэмжээ
- 12-p сард

Компанийн онцлох үйл явдлууд.

Netcapital Annual Report 2023




2008

- Машинаа унаад зээлээ ав бүтээгдэхүүнийг анх зах зээлд нэвтрүүлэв.
- Анхны салбараа Дорноговь аймагт нээж өргөжин тэлэв.
- 2009 оны Стандарт хэвшүүлэгч байгууллага.
- 2009 оны Топ-10 ББСБ



2010

- 2011 оны 1 дүгээр улиралд компанийн дүрмийн санг 335.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1.449 тэрбум төгрөгт хүргэв.
- Компанийн гүйцэтгэх захирал Н.Ундрах 2011-2012 оны онцлох энтрепренер болов.
- 2011 оны Топ-10 ББСБ



2009

- Зээл, итгэлцэл, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлж үйл ажиллагаагаа эхлүүлэв.



2011

- Grapecity Mongolia LLC-ын Achidbanker системийг үйл ажиллагаандаа ашиглаж технологийн шийдлийг нэвтрүүлэв.
- MXAYT-ийн Платинум гишүүн 2010 оны Топ-10 ББСБ



Компанийн онцлох үйл явдлууд.

Netcapital Annual Report 2023



- IT Zone ХХК-ийн "GreenERP" хүний нөөцийн системийг нэвтрүүлэв.
- Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүд болон, Дархан, Эрдэнэт хотуудад шинэ салбаруудаа нээж томоохон тэлэлт хийв.
- Грэйпсити Монгол ХХК-ийн "Grape bank" банкны үндсэн системийг үйл ажиллагаандaa нэвтрүүлж технологийн дараагийн шатанд гарав.
- 2013 оны Топ-10 ББСБ



- "Монголын ББСБ" холбооноос зохион байгуулдаг сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд 3 жил дараалан түрүүлж шилжин явах цомыг мөнхлөв.
- 2015 оны Шилдэг татвар төлөгч

- Бичил санхүүгийн Олон улсын зөвлөх Jonathan Hiebert-ийг менежментийн багтаа урьж ажиллуулав.
- Гранд экспо ТОП-5 ББСБ нэгээр шалгаав.
- 2012 оны Топ-10 ББСБ



- Мост мони төлбөр тооцооны системийг нэвтрүүлж салбартай анхны бэлэн бус гүйлгээний хэлбэрт 100% шилжив.
- 2014 оны Шилдэг татвар төлөгч



Компанийн онцлох үйл явдлууд.

Netcapital Annual Report 2023



2016

- Гар утсанд суурилсан “Мобайл кредит” зээлийн эрх бүхий шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.
- Сүхбаатар дүүрэгт шинэ салбараа нээв.
- Автомашины лизингийн “ӨӨДӨӨ” бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.



2018

- Нийгмийн хариуцлагын хүрээнд Арабын нэгдсэн Эмират улсад болсон Хүн төрөлхтний эв нэгдлийн билэг тэмдэг “Special Olympic” - ийн наадмын мэдээллийн ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд “ХЭЛ хязгаар ҮГҮЙ” төслийг хэрэгжүүлж OPEN WORLD сургалтын төвтэй хамтран алслагдсан дүүргийн 300-н хүүхдийг үнэ төлбөргүй АНГЛИ хэлний сургалтад хамруулав.
- Санхүүгийн боловсрол олгох, сургалт үйлчилгээ явуулах зорилгоор НэтАкадеми ХХК-ийг үүсгэн байгуулж үйл ажиллагаа эхлүүлэв.

- 2016 оныг сургалтын жил болгож мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж амжилттай хэрэгжүүлэв.



2017


- Нийгмийн хариуцлагын хүрээнд “10,000 ناس” (10,000 people) инээмсэглэл” төслийг амжилттай хэрэгжүүлэв.
- Сонгинохайрхан болон Чингэлтэй дүүрэгт шинэ салбарууд нээв.
- Ребрэндинг хийв.
- ББСБ холбооны “Оны шилдэг нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч байгууллага”
- Харилцагчидруу чиглэсэн “ӨӨРТӨӨ ЗОРИУЛАХ 60 МИНУТ” хөтөлбөрийг хэрэгжүүлэв.



2019

Компанийн онцлох үйл явдлууд.

Netcapital Annual Report 2023



2020

- Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт “Хороолол” салбар шинээр нээгдэв.
- Да Хүрээ авто худалдааны төвд шинэ салбараа нээв.
- Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт “Сансар” салбар шинээр нээгдэв.



2021.Q2

- CRM hubspot -г албан ёсны эрхтэйгээр нэвтрүүлэв.
- Монгол Ипотекийн Корпорацитай Зээлийн багц худалдах, худалдан авах гэрээ байгуулж, эх үүсвэр татах Хамтын ажиллагааг эхлүүлсэн.
- Төвийн нэгжийн үйл ажиллагаанд OKR, Scrum, JIRA-г нэвтрүүлж, ашиглаж эхлэв.



2021.Q3

НҮБ-ын “Тогтвортой хөгжил 2030” хөтөлбөрийн хүрээд Эрүүл мэндийг дэмжих, Чанартай боловсролыг дэмжих, Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих зорилтуудын хүрээнд:

- Эрүүл уушги -10,000 маск аян
- Аюулгүй гарц - Бага насны хүүхдүүдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх аяныг Баянгол дүүргийн тээврийн цагдаагийн газартай хамтран ажиллав.
- Финтек шийдэл бүхий цахим зээлийн үйлчилгээний NETAPP-ийг зах зээлд нэтрүүлэхээр төсөл өхлэв.




2021.Q1

- “Амар” зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.
- Улаанбаатар хотод 22 авто худалдааны төвд шинэ салбараа нээв.
- Компанийн бүтэц зохион байгуулалт тэлж, Шинээр 8 газар нэгжийг бий болгов.
- Компанийн Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлсээ шинэчлэн батлав.

Компанийн онцлох үйл явдлууд.

Netcapital Annual Report 2023



2021.Q3

- Цахим мөнгөний зөвшөөрөл авав.
- Группийн актив хөрөнгө 2 дахин өсөлт хийв
- Компанийн Стратеги төлөвлөгөөнд “Balanced Scorecard” аргачлалыг ашиглаж эхлэв.



2021.Q4

- Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт “Их Монгол” салбар шинээр нээгдэв.



2021.Q4

- Финтек шийдэл бүхий цахим зээлийн үйлчилгээний NETAPP-ийг зах зээлд нэтрүүлэв



2021.Q4

- Олон улсын банк санхүүгийн салбарын онлайн сэтгүүл болох “Global Banking & Finance Awards”-н 2021 оны шилдэг ББСБ болов.
- Хөрөнгө оруулалт, эх үүсвэр татан төвлөрүүлэх зорилгоор Шангри Ла оффисын 22 давхарт үйл ажиллагаа явуулж эхлэв.

Компанийн онцлох үйл явдлууд.

Netcapital Annual Report 2023



2022.Q1

- Олон улсын санхүүгийн тайлагналын IFRS9 Стандартыг нэвтрүүлэхээр шийдвэрлэж, төсөл эхлэв.
- NetPay апликацийний шинэ хувилбарыг гаргаж, дансны хуулга дээр үндэслэн зээлийн оноо бодлог боломжтой болов. Мөн төлбөр тооцооны боломжууд нэмэгдлээ.



2022.Q3

- ТоС Холбоонд гишүүн байгууллагаар элсэж Компанийн Тогтвортой орлогын санхүүжилтийн (ТоС) бодлогыг баталлаа.
- Засаглалын үнэлгээгээр ТОП-5 ББСБ-н 1 болов.
- ISO27001:2013 мэдээллийн аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлэв.
- Компанийн 27 салбарт OKR, Scrum, JIRA-г бүрэн нэвтрүүлэв.

- Олон улсын Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 нэвтрүүлсэн анхны ББСБ болов.
- Компанийн үндсэн систем буюу корбанкийг дотооддоо хөгжүүлж, нэвтрүүлэхээр шийдвэрлэж, төсөл эхлэв.
- Орон нутагт шинээр 12 салбарыг зэрэг нээв.
- Улаанбаатар хотод “Парк-Од” салбар, “Гранд Плаза” салбар, “Гэгээнтэн” салбар шинээр нээгдэв.



2022.Q2

- Харилцагчийн үйлчилгээний газрыг шинээр байгуулав.
- Дижитал зээлийн салбарыг шинээр нээв.
- Machine learning аргачлалаар орон сууцны үнэлгээг таамагладаг болов.
- Гаалтай лизинг бүтээгдэхүүний процесс автоматжуулалтыг амжилттай хийж, 30минутанд зээл олгодог боллоо.



2022.Q4

Компанийн онцлох үйл явдлууд.

Netcapital Annual Report 2023



2023.Q1

- Өөрсдийн хөгжүүлсэн “NetCore” үндсэн системийг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, Grapebank system-г унтраав.
- Дансны хуулгаас орлого тооцох моделийг үйл ажиллагаанд нэвтрүүлж, зээлийн судалгаанд ашиглаж эхлэв.



2023.Q3

- Засаглалын үнэлгээгээр 2 дах жилдээ ТОП-5 ББСБ-н 1 болов.
- ISO9001:2015 стандартын Магадлан аудит-2т амжилттай хийгдэж, стандарттаа баталгаажуулав.
- ISO9001:2015 стандартын Австрали дах төв оффисоос TQCSI Mongolia компанийн шилдэг харилцагч байгууллагаар биднийг өргөмжлөв.
- Харилцагчийн үйлчилгээний шинэ стандартыг нэвтрүүлж, харилцагчийн гомдолыг шийдвэрлэх хугацаа 104 цагаас 4 цаг болж буурав.

- Орон нутагт шинээр 7 салбарыг зэрэг нээж, 40+ ажлын байрыг шинээр бий болгов.
- NET-Knowledge sharing арга хэмжээг зохион байгуулав.

NETCORE

2023.Q2

- COSO ERM эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв.
- Тэнгис салбарыг шинээр нээв.
- “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх” тусгай зөвшөөрлийг СЗХ-с авав.
- JIRA-Helpdesk системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэв.
- Сингапур улсын Kilde хөрөнгө оруулалтын сангаас \$9сая эх үүсвэр татах хэлцэл амжилттай хийгдэж, гэрээ үзэглэв.



ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ.

NetCore

Дотооддоо үндсэн систем болох Core Fintech системийг хөгжүүлэн, үйл ажиллагаандaa амжилттай нэвтрүүллээ

- | | |
|---------------|--------------------------------|
| ✓ Хөгжүүлэлт | ✓ 33 модуль |
| ✓ Тест | ✓ 18 систем интегрэйшн |
| ✓ Мигрэйшн | ✓ +LOS, BPFM, Digital Channels |
| ✓ Нэвтрүүлэлт | ✓ 51 тайлан, 102 баримт |



Онцлох ажил.

Шинээр 7 салбарыг зэрэг нээв.

Булган, Төв аймаг, Хэнтий, Сүхбаатар, Дундговь аймаг болон Налайх, Багануур дүүрэгт бид шинээр 7 салбарыг зэрэг нээж, 40+ ажлын байрыг бий болголоо. Ингэснээр Монгол улсынхаа 21 аймаг, 9 дүүрэгт нийт 36 салбар үйл ажиллагаа явуулж байна.



Онцлох ажил.

Дижитал салбар


Дижитал зээлийн үйлчилгээ авдаг харилцагч нартаяа улам ойртож, бид 2022 онд анх “Дижитал салбар”-ыг шинээр байгуулж байсан бол 2023 онд шинээр 2 дахь салбар болох “Тэнгис салбар”-г байгуулж, 20+ ажлын байрыг дахин бий болголоо.



Онцлох ажил.

Харилцагчийн үйлчилгээний стандарт ба гомдол шийдвэрлэлт

Харилцагчийн үйлчилгээний шинэ стандартыг баталж, үйл ажиллагаандaa мөрдөж эхэллээ. Ингэснээр харилцагчийн Гомдол шийдвэрлэх дундаж хугацаа 48 цаг байсныг 1.2 цаг болгож буурууллаа.



Онцлох ажил.

ISO 9001:2015 стандартын магадлан аудит амжилттай хийгдлээ.



TQCSI баталгаажуулалтын компанийн Австрали улс дах төв оффисоос хийдэг жил бүрийн үнэлгээгээр “Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК-г **менежментийн системээ тасралтгүй сайжруулж буй шилдэг харилцагч байгууллагаар** өргөмжиллөө.

- **ISO 9001:2015 ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО**

ISO 9001:2015 Стандартын PDCA циклыг хангаснаар:

1. ЧУТ-ны шаардлагыг бүрэн ханган ажиллаж, шат бүрт хяналт, стандарт тогтолцоотой болов;
2. Хэрэглэгчийн сэтгэл ханамжид сууринсан бүтээгдэхүүн үйлчилгээг гаргаж, тасралтгүй сайжруулдаг болов;
3. Харилцагчийн үйлчилгээний чанарыг тогтмол хэмжиж, сайжруулалтын хэрэгжилтийг шуурхай ханган ажилладаг болов;
4. Эрсдэл ба боломжуудыг урьдчилан тооцож харилцагчийн хэрэгцээг бүрэн хангасан чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэдэг болов;
5. Байгууллагын гадаад, дотоод орчны шинжилгээг Олон улсын аргачлалын дагуу хийж, стратеги төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлдэг болов;
6. Олон улсын зах зээлд хүлээн зөвшөөрөгдөж, хөрөнгө оруулалт, эх үүсвэр, томоохон төслүүдэд бүрэн хамрагдах боломжтой болов;

Эрсдэлийн удирдлага



Эрхэм зорилго:

Дижитал банкийг таны гарг

Алсын хараа:

Дижитал эринд финтек хувьслаар манлайлна

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

- МАБ-ын бодлого
- Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг удирдах журам
- Мэдээллийн ангиллын журам;
- МАБ-ын аюулгүй байдлын үл тохирол ба залруулах арга хэмжээний журам.
 - МАБ-ын эрсдэлийг бууруулах үнэлгээ, хариу арга хэмжээ
 - МАБ-ын эрсдэлийн үнэлгээ, хариу арга хэмжээ;
 - МАБ-ын хуулийн нийцлийн үнэлгээ;
 - Системийн эмзэг байдлын үнэлгээ.

ЭРСДЭЛИЙН БОДЛОГО

Бодлого, журам, заавар:

- ❑ Эрсдлийн бодлого
- ❑ Эрсдлийг удирдах ерөнхий журам
- ❑ Зээлийн эрсдлийг удирдах журам
 - ЗМС-д мэдээлэл өгөх авах заавар
 - Хүү шимтгэл тооцох аргачлал
- ❑ Санхүүгийн эрсдлийг УЖурам
- ❑ Нийцлийн эрсдлийг удирдах журам
 - Дотоод хяналтын хөтөлбөр
 - Сэжигтэй гүйлгээний заавар
- ❑ Бусад дагалдах журам заавар

Хэрэгжилтийг хангах болон Дотоод хяналт:

- ❑ COSO ERM төлөвшлийн үнэлгээ;
- ❑ Мөнгө угаахтай тэмцэх үнэлгээ;
- ❑ Санхүү бүртгэлийн төлөвшлийн үнэлгээ;
- ❑ Эх үүсвэр эзэмшигчийн эрсдэл даах чадварын үнэлгээ;
- ❑ Зээлийн үйл ажиллагааны дотоод хяналт;
- ❑ Эрх дамжуулалтын дотоод хяналт; систем

Тогтвортой санхүүжилтийн бодлого

- ТоC-ын бодлого
- БОНЗ эрсдэлийн удирдлагын журам;
- Тогтвортой санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэх засаглалын удирдамж.

➢ БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээг нийт зээлийн багцын 3.1%-д үнэлсэн.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

COSO ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

2023 ОНД COSO ERM ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭСЭН

1
ЗАСАГЛАЛ БА СОЁЛ
5 ЗАРЧИМ

2
СТРАТЕГИ БА ЗОРИЛГО
4 ЗАРЧИМ

3
ЭРСДЭЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ
5 ЗАРЧИМ

4
ХЯНАЛТ,
САЙЖРУУЛАЛТ
3 ЗАРЧИМ

5
ТАЙЛАГНАЛ БА
СУВАГ
3 ЗАРЧИМ

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ПРОЦЕСС



төлөвлөлт ба тайлагна



ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ,
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ



БИЗНЕСИЙН ТАСРАЛТГҮЙ
АЖИЛЛАГАА



МУТСТ, СЭЖИГТЭЙ
ГҮЙЛГЭЭНИЙ ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГА

ДОТООД ХЯНАЛТ ТАЙЛАГНАЛ

Зээлийн үйл ажиллагааны

Эх үүсвэрийн үйл
ажиллагаа

Цахим мөнгөний үйл
ажиллагаа

Валют арилжааны үйл
ажиллагаа

Эрсдэлийн удирдлага.

Netcapital Annual Report 2023

➤ Эрсдэлийн удирдлага

Группийн үнэ цэнийг хамгаалах зорилгоор эрсдэлийн удирдлагын багийг бүрдүүлэн, ирээдүйд учирч болох эрсдэлийн төрлийг тодорхойлж, хянаж, удирдан ажиллаж байна. Эрсдэлийг удирдсанаар инновацийг дэмжих, гүйцэтгэлийг сайжруулах боломж бүрдсэн.

➤ Эрсдэлийн удирдлагын засаглал, тогтолцоо

Групп нь эрсдэлийн удирдлагын засаглалаа 2023 онд Гүйцэтгэх захирлын эрх үүрэгт хамаарах хороодоор дамжуулан хэрэгжүүлсэн бол **2024 оноос ТУЗ-ийн дэргэд “Эрсдэлийн удирдлагын хороо”-г шинээр байгуулахаар шийдвэрлээд байна.** Группийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын гурван бүсийн зарчим баримтлах ба эрсдэлийг хариуцах, хянах удирдах, засаглалыг бүрдүүлэх чиг үүргүүдийг хуваарилан ажилладаг.

➤ Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаа

Гүйцэтгэх захирлын эрх үүрэгт хамаарах эрсдэлийн удирдлагын хороо нь батлагдсан дүрэмд заасан бүрэлдэхүүн, давтамж, хэлэлцэх асуудлын дагуу 14 хоног тутам хуралдаж, эрсдэлийг хэлэлцэн, шийдвэрлэх арга хэмжээ авч ажилладаг.

2023 онд нийт 16 удаа хуралдсан бөгөөд үүсч буй эрсдэлийг шийдвэрлэх, хяналтын тайланг хэлэлцэх, эрсдэлийн хязгаар лимитийн хэрэгжилтийг хянах, МУТСТ хууль, журам болон Зохицуулагч байгууллагын шалгуур, шаардлагыг хангуулах гэх мэт дүрэмд заасан хэлэлцэх шаардлагатай асуудлуудыг бүрэн хамруулж, шийдвэрийн хэрэгжилтийг Эрсдэлийн удирдлагын газраас хянаж байна.

➤ Эрсдэлийг удирдах баримт бичгүүд

Группийн нийт эрсдэлийг дараах 8 ерөнхий төрөлд ангилж байна. Үүнд:

- Стратегийн эрсдэл, Санхүүгийн эрсдэл, Зээлийн эрсдэл, Үйл ажиллагааны эрсдэл, Нийцлийн эрсдэл, Нэр хүндийн эрсдэл, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэл, Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлага
- Дээрх эрсдэлийн төрөл тус бүрт нь эрсдэлийг удирдах журам болон арга аргачлалуудыг боловсруулан мөрдөж байна.

1. Стратегийн эрсдэлийн удирдлага

Группийн стратеги төлөвлөгөөнд нөлөөлөх гадаад дотоод орчны эрсдэл болон боломжийг Гүйцэтгэх удирдлагын багаар жил бүр шинэчлэн тодорхойлж, авах арга хэмжээг төлөвлөдөг. Хэрэгжилтийг OKR төлөвлөгөөний гүйцэтгэлд үндэслэн хянах замаар ханган ажиллаж байна.

2. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Групп нь Зохицуулагч байгууллагаас тавьдаг зохистой харьцааны шалгуур болох өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, актив хөрөнгийн төвлөрөл, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх хэмжээнд ханган ажиллалаа.

➤ Зээлийн эрсдэлийн удирдлага

Групп нь Зээлийн эрсдэлийг удирдах журмаар зээлдэгч, зээлийн бүтээгдэхүүн, барьцаа хөрөнгийн эрсдэлийн хязгааруудыг тодорхойлон зээлийн оновчтой багц бүрдүүлэх, зээлийн эрсдэлийн дохиог эрт илрүүлэх, зээлдэгчийг таних скорингт тасралтгүй сайжруулалт хийх, барьцаа хөрөнгийн үнэлгээг автоматжуулж, хүнээс хамаарсан эрсдэлийг бууруулах зарчим баримтлан ажиллаж байна.

➤ Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ISO9001:2015 стандартын дагуу SIPOC аргачлалаар тодорхойлсон Группийн хэмжээний нийт процессын эрсдэлийг тодорхойлж, шийдвэрлэхээр төлөвлөсөн хариу арга хэмжээний хэрэгжилтийг улирал бүр хянан удирдаж байна.

➤ Нийцлийн эрсдэлийн удирдлага

Групп нь МУТСТ хууль болон СЗХ-оос гаргасан МУТСТ үйл ажиллагааны журмын дагуу Нийцлийн эрсдэлийг удирдах журмыг боловсруулан батлуулж, тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. Эцсийн өмчлөгч тодорхойлох, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хориг жагсаалтад орсон харилцагчийг таних зэргээр МУТСТ хууль болон СЗХ-ны журамд нийцэхгүй, эрсдэлтэй харилцагчийг таних автомат системийг нэвтрүүлсэн.

➤ Нэр хүндийн эрсдэлийн удирдлага

Группийн талаарх сошиал дахь эерэг, сөрөг мэдээллийг автоматаар цуглуулах програмыг үйл ажиллагаанд ашиглаж, нэр хүндийн эрсдэлээс урьдчилан сэргийлж байна.

➤ Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

ББСБ-ын салбар өргөжихийн хэрээр байгууллагууд технологийн дэвшил, мэдээлэл солилцох, боловсруулах хурдаар өрсөлдөж байгаа тул Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэл шууд хамааралтайгаар нэмэгдэж байна.

Иймд байгууллагын үнэ цэнтэй мэдээллийн нууцлалтай, хүртээмжтэй, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог /МАБУТ/ хортой кодын эсрэг хяналт, физик нэвтрэлтийн хяналт, системийн эмзэг байдлын хяналт, эрхийн зохицуулалт, логийн удирдлага, digital forensic гэх мэт хяналтуудаар дамжуулан бий болгож, эрсдэлийг удирдаж байна. Мөн үйл ажиллагаанд ISO27001:2013 стандартыг нэвтрүүлж, 2024 оны магадлан аудитад амжилттай бэлтгэж байна.

➤ Байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

- Групп нь байгаль орчин, олон нийтэд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа эрхэлдэггүй бөгөөд хориглох үйл ажиллагааны чиглэлийг “Эрсдэлийн удирдлагын бодлого”-оор баталдаг.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд тусгайллан төсөв баталж, хэрэгжүүлж байна.
- Хөдөлмөр, эрүүл мэнд аюулгүй байдлын хувьд бүх ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрны хэвийн нөхцөлөөр бүрэн хангаж, эрсдэлээс сэргийлдэг.
- 2022 онд бид Тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааг нэвтрүүлж, ТоC бодлого болон ТоC бодлогыг хангах зорилгоор “Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлагын журам”-г баталж, аргачлал, систем хөгжүүлэлтийг бий болгон, хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Уг журмын хүрээнд **БОНЗ-ЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ НИЙТ ЗЭЭЛИЙН БАГЦЫН 3.1%-Д ҮНЭЛСЭН** ба бизнесийн зээл авч буй харилцагчдын эрсдэлийг үнэлж, эрсдэл өндөртэй харилцагчид эрсдэл бууруулах шаардлагыг тавьж, ТоC-н зарчмыг дэмжиж ажиллаж байна.

Дотоод аудитын тогтолцоо

Netcapital Annual Report 2023

➤ Дотоод аудитын зорилго.

Дотоод аудитын газар нь “Нэткапитал Финанс корпораци ББСБ” ХХК-ийн Компанийн засаглал, стратеги, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын процессын үр дүнтэй байдалд эрсдэлд суурилсан, мэргэжлийн, хараат бус аудитыг гүйцэтгэн үнэлж, тэдгээрийг тогтмол сайжруулах зөвлөмж болон баталгаажуулалтаар хангана.

➤ Дотоод аудитын тогтолцоо.

1. Дотоод аудитын газар нь хараат бус байх ба ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд харьялагдаж, тайлагнаж, мөн дараахыг шийдвэрлүүлнэ. Үүнд:
 - ✓ Дотоод аудитын дүрэм болон журмыг батлуулах;
 - ✓ Эрсдэлд суурилсан дотоод аудитын жилийн төлөвлөгөөг батлуулах;
 - ✓ ДАГ-ын төсөв болон нөөцийн төлөвлөгөөг батлуулах;
 - ✓ Менежментийн талаас ДАГ-ын үйл ажиллагааны хамрах хүрээ;
2. ДАГ нь нэгж аудитыг сонгох, аудитын хамрах хүрээ, зорилго, шалгуур үзүүлэлт, аудитын давтамж, тайлангийн агуулгыг тодорхойлоходоо компанийн бусад газар, нэгжийн нөлөөллөөс ангид байна. Ингэснээр хараат бус, бодит байдлыг бий болгоно. Хараат бус, бодит байдал алдагдсан эсвэл алдагдах нөхцөл үүссэн тохиолдолд Аудитын хороонд мэдэгдэнэ.

➤ Дотоод аудитын бүтэц ба зохион байгуулалт.

1. ДАГ нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд шууд харьялагдаж тайлагнана.
2. ДАГ нь газрын захирал, ахлах аудитор, аудитор гэсэн бүтэцтэй байна.
3. ДАГ нь Олон улсын дотоод аудитын стандарт ба ёс зүйн дүрэм, Дотоод аудитын газрын бодлого, дүрэм, журамд нийцэж ажиллана.

➤ Дотоод аудитын чиг үүрэг.

1. Үйл ажиллагааны аудит (Төвийн нэгж, салбар, мэдээллийн систем);
2. Санхүүгийн аудит;
3. Нийцлийн аудит;
4. Засаглалын аудит;
5. Зөвлөх үйлчилгээний аудит
6. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо



ANNUAL REPORT

NETCAPITAL 2023



NET CAPITAL
financial group